

НОМЫН ШҮҮМЖ

Рах Mongolica №2, 2016 он: 148-158 хуудас

МОНГОЛ УЛС БА ИХ ГҮРНҮҮД XX ЗУУНД

Товч агуулга: *Р.Болдын «Тусгаар тогтнол ба түүнийг хүлээн зөвшөөрсөн нь»: АНУ-Орос-Хятадын ашиг сонирхолын гурвалжин дахь Монгол. 1910-1973 он.»-М., Весь мир, 2015., 427с. нэгэн сэдэвт зохиолын шүүмжийг толилуулж байна. Уг зохиолд Монгол Улсын гадаад харилцааны тогтолцоонд Монгол-Америкийн харилцааны эзэлж байгаа байр сууринд онцгой анхаарал хандуулжээ. Мөн Монгол Улсын Орос, Хятад, АНУ зэрэг орнуудтай харилцсан түүхэн асуудлуудад дүн шинжилгээ хийсэн байна.*

Түлхүүр үг: *Монголын гадаад бодлого, их гүрнүүд, Монгол-Америкийн харилцаа, шүүмж, Р.Болдын нэгэн сэдэвт зохиол, Оросын үүрэг, олон улсын байдал*

Сүүлийн 30 жилийн хугацаанд монголын түүхчид болон дэлхийн монгол судлал Зүүн Ази дахь олон улсын харилцааны тогтолцоонд Монгол Улсын эзлэх байр суурьт ихээхэн анхаарал хандуулж байна. Энэ хугацаанд XX зууны олон улсын харилцааны тогтолцоон дахь Монголын түүхийн үзэл баримтлалын асуудлууд, мөн Хятад, Орос, Япон ба Өрнөдийн орнуудтай харилцах Монгол Улсын харилцааны асуудлуудыг тусгасан монголын болон гадаадын эрдэмтдийн суурь судалгааны бүтээлүүд хэвлэгдэн гарчээ. Уг сэдвээр Ш.Сандаг, Л.Жамсран, Ц.Пунцагноров, Н.Ишжамц, Ж.Болдбаатар, Ц.Батбаяр, О.Батсайхан, Б.Баабар, Б.Лигдэн, Ж.Урангуа, Ч.Далай, Л.Хайсандай болон бусад нэрт түүхчид томоохон судалгаа хийсэн байдаг.

XX зууны монголын түүх судлалд Монгол Улсын үндэсний тусгаар тогтнол, түүний олон улсын статусыг тогтооход гол үүрэг гүйцэтгэсэн Орос, Хятад, Япон зэрэг орнуудын хоёр талт харилцаа сайтар тусгагджээ. Ялангуяа харилцааны гурвалжинд голлох үүрэг гүйцэтгэж буй Хятад, Оростой харилцах дипломат, эдийн засгийн болон соёлын харилцаа илүү гүнзгий судлагдсан байна.

XX зууны Монгол-Америкийн харилцааг Ц.Пунцагноров, Н.Ишжамц, Л.Хайсандай, А.Дамдинсүрэн, Ж.Болдбаатар, Ц.Ишдорж, Д.Уламбаяр, Н.Галиймаа, М.Хурметхан, түүнчлэн АНУ-ын Алиша Кампи зэрэг судлаачид судалдаг билээ.

Монгол Улсын төрийн нэрт зүтгэлтэн, түүхийн ухааны доктор Равдангийн Болд Монгол-Америкийн харилцаа болон Монгол Улсын түүх, гадаад бодлогод америкийн хүчин зүйлийн гүйцэтгэсэн үүргийг шинэлэг, өвөрмөц байдлаар тайлбарласнаа санал болгож байна.

Москва хотын “Весь мир” хэвлэлийн газар 2015 онд Р.Болдын «Тусгаар тогтнол ба түүнийг хүлээн зөвшөөрсөн нь: АНУ-Орос-Хятадын ашиг сонирхолын гурвалжин дахь Монгол. 1910-1973 он» суурь судалгааны нэгэн сэдэвт зохиолыг хэвлэсэн байна. Тус номыг монгол судлаач, орчуулагч Ю.Кручкин монгол хэлнээс орос хэлрүү хөрвүүлсэн бол өмнөх үгийг ОХУ-ын ШУА-ийн Дорнодахины хүрээлэнгийн тэргүүлэх ажилтан, улс төрийн ухааны доктор А.С.Железняков бичжээ.

Дэлхийн Монгол судлалд анх удаа америкийн ховор түүхэн эх сурвалж, баримт бичигт тулгуурласан 1910-1973 оны хоорондох Монгол-Америкийн харилцааны тухай суурь судлагааны бүтээл хэвлэгдлээ. Монгол Улсын үндэсний тусгаар тогтнолд Америкийн хүчин зүйлийн гүйцэтгэсэн үүргийн талаарх тайлбарыг тун өвөрмөцөөр, чингэхдээ орчин үеийн түүх бичлэгт нийтийн хүлээн зөвшөөрснөөс тэс өөрөөр хийжээ.

А.С.Железняковын дурдсанаар, Равдангийн Болд бол монголын зэвсэгт хүчин, тагнуул болон дипломат албаны элит удмын төлөөлөгч юм. Түүний эцэг С.Равдан хурандаа-генерал (1907-1972), том ах Р.Батаа нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх, Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн (8-р тал) нарийн бичгийн даргаар ажиллаж байсан. Равдангийн Болд 1980 онд Москва хотын Цэрэг-Дипломатын академийг дүүргэж, БНМАУ-ын Зэвсэгт хүчний жанжин штаб, БХЯ-ны дэргэдэх Стратеги судлалын хүрээлэнгийн захирал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн аюулгүй байдал, гадаад бодлогын зөвлөх, Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн нарийн бичгийн дарга, Тагнуулын Ерөнхий газрын дарга (2007-2012), АНУ-д суух Онц бөгөөд бүрэн

эрхт Элчин сайд (2003-2007), Австралид суух Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд (2012-2015) зэрэг албуудыг тус тус хашиж байв. Эл нэгэн сэдэвт зохиолын зохиогч Монгол Улсын төрийн, хүчний болон дипломат өндөр албан тушаалыг олон жилийн турш амжилттай хашсан туршлагаа эрдэм судлалын ажилтайгаа амжилттай хослуулж байгаа билээ. Тиймээс уг нөхцөл нь эл шинжлэх ухааны бүтээлийн үнэ цэнэ, шинжлэх ухааны ач холбогдолыг илэрхийлнэ. Р.Болдын докторын диссертаци Монгол-АНУ-ын хоорондох дипломат харилцааны үүсэл, хөгжилд зориулагдсан байна. Тэрээр 2014 онд 1939 оны Халх голын дайнд зориулагдсан “Зарлаагүй дайн” номоо хэвлүүлж байжээ.

Р.Болдын нэгэн сэдэвт зохиолын үнэ цэнэ АНУ-ын Үндэсний архивын түүхэн эх сурвалжийг өргөн хүрээнд хамарсанд оршино. Тухайлбал: “1910-1919 оны Хятадын дотоод хэрэгт хамаарах материалууд”, “1910-1919 оны Хятадын гадаад хэрэгт хамаарах материалууд”, “Оросын гадаад харилцаанд хамаарах материалууд. 1910-1919”, мөн 1921-1927 онд Хаалган хотод ажиллаж байсан АНУ-ын Консулын 50 хавтас бүхий материал, “Гадаад Монгол” хавтаст материал (13-р тал) зэргийг дурьдаж болно. Мөн “АНУ-ын цэргийн тагнуулын мэдээлэл, Хятад. 1911-1941” АНУ-ын цэргийн тагнуулын нууц материал, “Алс Дорнод дахь цэрэг-улс төрийн байдал” 5 боть зэрэг бусад эх сурвалж, түүхэн материалыг ашигласан байна. Зарим үнэт түүхэн баримтуудыг зохиогч анх удаа номын Хавсралтад (21 хавсралт, х.348-393) хэвлэсэн байна. Зарим онцгой ач холбогдол бүхий баримт бичгүүдийг сканнердсан хэлбэрээр хэвлэсэн нь уг зохиолыг улам үнэ цэнэтэй болгожээ. Мөн анх удаа дэлхийн монгол судлалд англи хэл дээрх шинжлэх ухааны эрдэм шинжилгээний бүтээл болон нийтлэл зохиолыг ийм өргөн хүрээнд ашигласан явдал боллоо.

“Гадаад Монголын АНУ-тай холбоо тогтоох оролдлого” эхний бүлэгт 1911-1921 оны хүнд хэцүү үеийг тусгасан байна. Энэ үед Монголын хувьд Орос Хятад хоёр улс гол гадаад хүч байсан бол Япон ч мөн тодорхой хэмжээгээр нөлөө бүхий улс байжээ. Р.Болд бүс нутгийн олон улсын харилцааны тогтолцоо, Зүүн-Хойд Ази, Монгол дахь АНУ-ын үүргийн талаар өөрийн тайлбарыг санал болгосон байна. Үүнээс өмнөх түүхэн зохиолуудад Монголын тусгаар тогтнол дахь Америкийн хүчин зүйлийг тэр болгон тодорхойлоогүй байдаг.

Бидний бодлоор, “АНУ-ын Ази дахь бодлого, Америк Оросын сэргөлдөөн” бүлгийн эхний хэсэгт зохиогчийн дэвшүүлсэн анхдагч санаа түүхэн талаасаа үнэмшилгүй санагдана. Учир нь тухайн бүс нутагт Орос Японы хоорондох сэргөөлдөөн нь үндсэн сэргөөлдөөн байсан ба үүнийг нөлөөллийн хүрээний 1907, 1910, 1912 оны дипломат гэрээнүүд гэрчилдэг. Мөн Чин гүрэнтэй (дараа нь Бүгд Найрамдах Иргэн улс), Их Британитай сэргөөлдөөнтэй байсныг дурдаж болно. Үнэн хэрэгтээ энэ үед Орос АНУ-ын стратегийн хандлага маш их ялгаатай байсан. АНУ “нээлттэй хаалганы бодлого” явуулж байсан бол Орос нөлөөллийн хүрээгээ тэлэхийн тулд нутаг дэвсгэрийг эзлэх бодлого явуулж байлаа. Бүс нутаг дахь Орос АНУ-ын ашиг сонирхол харилцан зөрчилдөөнгүй, харин ч эсрэгээрээ, олон талаар давхацсан энхийн шинж бүхий байв.

Р.Болд бичихдээ: «XIX зууны хоёр дахь хагасаас Хаант Орос Алс Дорнодыг эзэлж, АНУ Азид өөрийн бэхлэлтийг байгуулж эхэлсэн нь тэдгээрийг Манжуурт сэргөлдөхөд хүргэсэн. Хэрэв Хаант Орос өөрийн нөлөөллийн хүрээгээ газар нутгуудыг нэгтгэн өргөжүүлэх замаар хүчээр тогтоосон бол Америк нь худалдаагаа өргөжүүлэх замаар өөрийн нөлөөгөө нэмэгдүүлэхийг зорьж байснаараа ялгаатай байлаа” гэжээ. (24-р тал). Түүхэн баримтад таарахгүй зохиогчийн уг дүгнэлттэй санал нийлэх аргагүй юм. Учир нь оросууд Сибирь болон Алс Дорнодыг үндсэндээ энхийн замаар эзэмшсэн бол Америк, Р.Болдын дээр дурдсанаар, хүчний аргаар эзэмшсэн байна. (17-р тал).

Р.Болдын эл санаа америкийн түүх судлалыг маш сайтар судалсантай холбоотой байх.

Уг номонд Хиагт-Хүрээ-Хаалганы чиглэлийн трансмонголын төмөр зам барих америкийн төлөвлөгөөний талаар, түүний хэрхэн бүтэлгүйтсэн тухай шинэ сонирхолтой мэдээлэл багтсан байна.

Р.Болд Гадаад Монгол дахь Оросын бодлогыг үнэлэхдээ 1910-1911 онд түүний идэвхижилтэнд анхаарал хандуулан, Монгол дахь Оросын түрэмгий санаархалыг гэрчилж буй барууны болон хятадын үнэлгээг дурьджээ. Р.Болд доктор Л.Жамсрангийн “монголын төлөөлөгчдийн 1911 оны 8 дугаар сард хийсэн айлчлал тусгаар тогтнолын асуудалд Оросын дэмжлэгийг авч чадаагүй. Энэ нь Орос

анхнаасаа монголчуудын тусгаар тогтнох хүсэлтийг дэмжээгүй” гэсэн үнэлгээнд тулгуурласан байна. (45-р тал).

Угтаа энэ бол тийм биш юм. Орос бүс нутаг дахь, түүний дотор Монголд өөрийн ашиг сонирхолоо тууштай хамгаалж ирсэн. Монгол дахь стратегийн ашиг сонирхолоо хамгаалахын тулд Орос, Хятад, Японтой дипломатын аргаар хоёрдмол бодлого явуулж байв. Өөрөөр хэлбэл, үүний шууд үр дүнд монголын тусгаар тогтнолыг сэргээн, төрийн байгуулалтыг бий болгож, 1911-1915 онд монголын арми, орчин үеийн санхүүгийн тогтолцоог байгуулсан билээ.

Үүнийг оросын дипломатч, хуульч Барон Нольде 1930 онд бичсэн “Алсын болон ойрын” түүхэн өгүүллийн “И.Я.Коростовец Монголд” хэсэгт дурьдахдаа: “Монгол улсыг байгуулсан нь Хаант Оросын томоохон дипломат ололт мөн. Түүний бат бэхийг түүхэн үйл явдал гэрчилнэ. “Цагаан хааны” нэрээр И.Я.Коростовецын 1912-1913 онд дипломат үүрэг гүйцэтгэхдээ байгуулсан бүтээн байгуулалт өдий болтол өөрчлөгдөөгүй байна... дайны өмнө И.Я.Коростовец болон Алс Дорнодын газрын дарга талийгаач Г.А.Козаков нар энэ сургуулийн тэргүүн эгнээг манлайлж байсан. Энэ хоёр хоёулаа уг томоохон түүхэн үйл явдлыг байгуулсан гавьяатай... И.Я.Коростовецын байгуулсан гэрээ Монгол Улсыг бүрэлдэн тогтноход шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн” хэмээн маш тодорхой үнэлсэн байдаг.¹

Тиймээс оросын бодлогыг “дотоод зөрчилтэй” (47-р тал), хоёрдмол болон холимог гэж тодорхойлох нь өөр утга агуулж буй. Оросын нийгэм-улс төрийн хүрээнд Монголын хөгжлийн хэтийн төлөв болон “монголын асуудлыг” хэрхэн шийдвэрлэсэн талаар олон янзын үнэлгээ байв, дипломатууд, цэргийн зүтгэлтнүүд, худалдаачид болоод нийгмийн зүтгэлтнүүд өөр өөрийн арга барилтай байсан ч оросын дипломат алба практик дээр тууштай нэгдмэл байр суурьтай байв. Хятад болон Тайваний түүхчдийн “Монголын тусгаар тогтнол Оросын дэмжлэг санаачлагаар хангагдсан” гэдэг нь үндэслэлгүй үзэл гэсэн Р.Болдын дүгнэлттэй санал нийлэх боломжтой юм. (47-р тал)

1. И.Я.Коростовец Девять месяцев в Монголии, Дневник русского уполномоченного в Монголии Август 1912 – Май 1913 г., Составитель О.Батсайхан, Редакторы О.Батсайхан, Ольга Бакич, Наками Тацуо, УБ., 2009, с.41

Орос-Монголын 1912 оны гэрээнд өгсөн зохиогчийн үнэлгээг түүхэн талаасаа алдаатай бөгөөд америкийн хүчин зүйлийг хэт дөвийлгөсөн гэж үзэж байна. “1910 оны гэрээний дараа Гадаад Монгол дахь Оросын бодлого идэвхжсэн нь Чин гүрэнд өөрийн нөлөөгөө нэмэгдүүлэх гэсэн Хаант Орос болон Америкийн өрсөлдөөнтэй холбоотой гэж үзэж болно. 1912 онд Хаант Орос Гадаад Монголтой улс төр, худалдааны гэрээ байгуулсан нь Орос Монголыг Америкийн “нээлттэй хаалганы” бодлогод татан оролцуулах хүсэлгүй байсантай холбоотой ба Монголыг бусад орнуудтай худалдаагаа өргөжүүлэхийн эсрэг арга хэмжээний нэг байж буферыг өөрийн нөлөөлөл дор үлдээх гэсэн хүсэлтэй байсан гэж тайлбарлаж болно”. (322-р тал).

Энэ нөхцөлд, тухайн судлаач Монгол-Америкийн харилцааг хэт удаан судалсантай холбоотойгоор тэдгээрийг өөрийн эрхгүй хэт дөвийлгөсөн гэж бодож байна. Бидний үзэж буйгаар, Монголын олон улсын статусыг дээшлүүлэн, Хятадад дипломат аргаар дарамт үзүүлэх замаар 1912 оны гэрээг баталсан учраас АНУ-ын оролцоо уг үйл явдалд сул байсан болов уу. Монгол Улс Орос-Монголын 1912 оны гэрээнд тулгуурлан АНУ болон бусад 9 оронд хандаж байжээ.²

Монгол дахь Америкийн худалдааны хэмжээ маш бага байхын зэрэгцээ тухайн орныг сонирхох америкийн дипломатч нарын сонирхол ч бас бага байсан учраас Орос, Хятад, Японы үндэсний эрх ашигтай харьцуулашгүй байлаа.

Бүхэлдээ, Монголын түүх, олон улсын харилцааны тогтолцоог шинжлэх ухааны үүднээс хөгжүүлэхийн тулд түүхэн үйл явцыг шинэлэг өнцгөөс харж уламжлалт бус аргаар үнэлэх шаардлагатай юм. Тиймээс Р.Болдын үнэлгээ нь түүхийн шинжлэх ухааныг эрчимжүүлэх үүрэг гүйцэтгэж байгаагаар үл барам XX зууны Монголын гадаад харилцааны талаарх бидний төсөөллийг улам гүнзгийрүүлж өгнө.

Р.Болдын нэгэн сэдэвт зохиолд Хятадын дипломат төлөөлөгчийн газрууд “монголын хэрэг явдлын” талаар хэр мэдээлэлтэй байсныг бүрэн харуулаад зогсохгүй 1912-1913 онд тусгаар тогтносон Монгол Улс байгуулагдсан тухай мэдээллийн таван лавлагааны тойм дүн шинжилгээ хийсэн байна. Уг номын нэг бүлэгт Монголын Засгийн

2. Монголын түүхийн эх сурвалж (1911-1921) УБ., 2013 г., с.135

НОМЫН ШҮҮМЖ

газар АНУ-тай харилцаа тогтоохын тулд ямар арга хэмжээ авч байсныг тусгайлан харуулдаг. 1912-1914 онд Монголын Засгийн газар гурван илгээлт явуулсныг бүрэн эхээр нь хавсралтад хэвлэсэн байна. Уг мэдээлэл бүрэн эхээрээ хэвлэгдсэн явдал нь орчин үеийн Монголын түүх судлалд шинжлэх ухааны томоохон хувь нэмэр оруулна.

Дээр дурьдсанаар, Харбин дахь 9 орны дипломат төлөөлөгчийн газарт Монголын Гадаад хэргийн яам нот бичиг хүргүүлсэн билээ. 1912 оны 12 дугаар сарын 13-нд Харбин дахь Америкийн консул Мейнард Монголын элч төлөөлөгч болон түүний монгол хэлнээс хятад хэлрүү хөрвүүлсэн нот бичгийг хүлээн авсан байдаг. Тухайн бичигт тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч, гэрээ байгуулж худалдааг хөгжүүлэх хүсэлтийг илэрхийлсэн байлаа. Зохиогчийн дүгнэлтээр, “америкчууд Монголын Засгийн газраас уг бичгийг хүлээн авсан талаар Орос Хятадын талд мэдэгдээгүй нь Монгол АНУ хоёр анхан шатны албан ёсны харилцаанд орсон” хэмээн дүгнэж болох юм. (70-р тал).

АНУ-ын Ерөнхийлөгч Т.В.Вильсон 1913 оны 4 дүгээр сарын 7-нд Гадаад Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхгүй хэмээн мэдэгдэж Монголын тусгаар тогтнолыг “буруу хүлээн зөвшөөрсөн” хэмээн Оросыг буруутгажээ. Бидний бодлоор, консулын газар захиа хүлээн авснаар албан харилцаанд орлоо гэж үзэж болохгүй, энэ талаар Америкийн төрийн департамент Хятадын Засгийн газарт албан ёсоор мэдээлсэн байна. 7 дугаар сарын 16-нд АНУ дахь Японы бүрэн эрхт элчин сайд Чинда Гадаад хэргийн яамны сайд Катод илгээсэн цахилгаандаа “Би маш нууц зэрэглэлийн №42 захидал өнгөрсөн сарын 11-нд хүлээн авлаа. Төрийн департаментад тавьсан Мацука нарийн бичгийн даргын хүсэлтийн дагуу өнгөрсөн сарын 4-ний өдрийн Хятад дахь Америкийн консулын цахилгаанд дараахь зүйлийг мэдээлж байна.

Хүрээнд байсан Хутагтаас захиа ирсэн. Тэрээр тухайн хэргийн талаар авах арга хэмжээний заавар өгөхийг хүссэн байна. 6 дахь өдрийн цахилгаанд сайд хариулахдаа захианд дурьдсан саналаас татгалзах ёстой хэмээжээ. Татгалзах хариуны талаар Хятадын Засгийн газартай зөвшилцөх заавар өгсөн байна”.³

3. О.Батсайхан Монголын сүүлчийн эзэн хаан VIII Богд Жавзандамба: амьдрал ба домог \Последний император Монголии Богд Жавзандамба хутагт: Жизнь и легенда\, УБ., 2011г., Второе издание, с.433

Эдгээр материал, үнэлгээ бүгд Монголыг “ертөнцийн хязгаар” болгон, Хүрээ-Хаалганы авто холбоог таслахаар зэхэж байсан Монгол дахь Оросын нөлөөг сөргөөр дүгнэх боломж өгч байгаа юм. 1913-1918 онд Америкийн эдийн засгийн оролцоо маш бага (5-6 АНУ-ын иргэн) байсан ч Хятад Хаалган хотыг нээлттэй болгож, хэдийгээр Америкийн 4 пүүс үйл ажиллагаа явуулж байсан ч, энэ хотод консулын газар нээх асуудал тавьж байлаа. (78-р тал). Р.Болд америкчууд ч, монголчууд ч дипломат харилцаа тогтоох хүсэлтэй байсан талаар олон баримт дэлгэсэн байна. Тухайлбал, 1919 оны 11 дүгээр сарын 10-нд Жалханз хутагт Бээжин дэх Америкийн элчин сайдын яаманд Хүрээнд Америкийн элчин сайдын яам нээх хүсэлт бүхий Богд гэгээний захиаг дамжуулан өгчээ. Мөн 1920 оны 4 дүгээр сард Монголын талаар тодорхой мэдээлэл авах зорилгоор Тяньжин дахь консул Ч.Эберхардт Хүрээнд ирсэн байна. (82-р тал). 1920 онд Хаалган хотод АНУ-ын консулын газрыг нээсэн нь, Р.Болдын үзэж буйгаар, “Хаалган болон Бээжингийн хооронд төмөр зам байсан хийгээд алсладгсан Гадаад Монгол Говь нутгаар заагдлагсан явдал байлаа”. (83-р тал).

Р.Болд 1921 оны Орос-Монголын харилцааг дүгнэхдээ Америкийн талыг хэт баримталж тэдний бодлогын эрх ашигт нийцүүлэн үнэлэлт дүгнэлт өгсөн тал ажиглагдаж байна: “Зөвлөлт Орос өөрөө Монголын Засгийн газрыг Орост зуучилахыг тулгаж улмаар Хятадтай харилцаанд орох шалтгааныг бий болгохын зэрэгцээ Монгол-Америкийн харилцааг хөгжин гүнзгийрэхээс урьдчилан сэргийлэх давхар зорилго агуулж байсан” гэжээ. (119-р тал) Ингэхдээ Орос /Барон Унгерн болон улаантнууд/ Монголын тусгаар тогтнолыг сэргээж, үндэсний арми, орчин үеийн санхүүгийн тогтолцоо, боловсрол болон эрүүл мэндийн салбарыг байгуулахад томоохон дэмжлэг үзүүлсэн талаар нэг ч үг дурьдаагүй байна. Дээр дурьдсанаар, АНУ Монголоос болж Хятадтай харилцаагаа муутгах сонирхолгүй байсан тул дипломат болон консулын харилцаагаа хөгжүүлээгүй билээ.

Монгол судлалд 1920-д оны үед Монголд үйл ажиллагаа явуулж байсан америкийн худалдаа тээврийн пүүсүүдийн талаарх мэдээлэл байдаг. Доктор Р.Болд уг номондоо Монгол-Америкийн харилцааг дэлгэрэнгүй үзүүлжээ. Хаалган хотын консулын газар (Сэмюэл Сокобин) АНУ-ын Засгийн газарт Монголд өрнөж буй үйл явдал

болон Зөвлөлтийн Монголд явуулж байгаа бодлогын талаар 1927 оны 4 дүгээр сар хүртэл мэдээллэдэг байжээ. (124-р тал) Консул С.Сокобин АНУ-ын худалдааны сонирхолыг хамгаалах зорилгоор 1922 оны 1-2 дугаар сард, мөн хожим нь хоёр удаа Хүрээнд ирж “Хүрээн дэх байдал, Монгол” нэртэй илтгэл бэлдэж байжээ. Харбин дахь консул Д.Хансон Манжуурын орос хэвлэлийн материал, Монголын талаарх орос америкчуудын санал асуулгын дүнг дамжуулдаг байв. Р.Болд уншигчдад Монголын Засгийн газрын дотоод бодлого, улс төрийн нөхцөл байдал болон Зөвлөлтийн нөлөөг үнэлж дүгнэхийг санал болгож байна. Мөн дэд-консул Стэнтон, консул Д.Кларк (1926-1927) нарын Монголын талаарх мэдээг дэлгэн үзүүлжээ. Номын зохиогчийн дүгнэлт америкийн дипломатч нарын тодорхойлолттой ижил байна, жишээ нь, “Зөвлөлтүүд Хятад-Монголын харилцаанд давхар тоглолт хийж байсан” гэх мэт. (133-р тал). Уг нь түүхч хүн түүхэн эх сурвалж, баримт бичгүүдэд шүүмжлэлтэй хандан үг дуугүй тэдгээрийг мөрдөх учиргүй байдаг.

Р.Болдын номын тусгай хэсэг Америк-Монголын худалдааны харилцаанд зориулагдсан байна (139-149-р тал). “XX зууны эхэнд хятадуудын Монголоос гаргаж байсан ноосны ихэнхи хувийг АНУ худалдан авдаг байсан. Харин хятадын худалдаачид Монголд шатахуун, сүлжмэл бүтээгдэхүүн, үр тарианы ихэнхи хувийг нийлүүлдэг байжээ.” (139-р тал). Хүрээ Хаалганы хооронд 1916-1924 онд авто тээвэр, шуудан холбоо явагдаж байжээ.

Түүнчлэн зохиогч Франц Ларсоны Монгол-Америкийн хооронд холбоо тогтооход гүйцэтгэсэн үүрэгт ихээхэн анхаарал хандуулсан байна. Ф.Ларсон Хүрээнд 1893 онд Библийн нийгэмлэгийн номлогчоор ирж 30 гаруй жил амьдран, монгол хэл сурч, нөлөө бүхий лам, хошуу ноёдтой холбоо тогтоож, 1900 оноос худалдаа эрхлэн, Хүрээ Хаалган хотод өөрийн эзэмшлийн байшинтай болсон байжээ. 1913-1914 онд тэрээр Монгол Түвдийн хэрэг хариуцсан Хятадын Засгийн газрын зөвлөх болсон. Р.Болдын дүгнэлтээр “Хятадын Засгийн газрын даалгавраар тэрээр Халхын ноёд лам нарыг Хятадын бүрэлдэхүүнд орохыг уриалж байв. Мөн Монголд төрийн алба хашихаар ирсэн ноёдыг Өвөр Монгол руу буцаах хятадын тагнуулын тусгай албаны даалгаврыг биелүүлж, Халхын ноёдыг Хятадын талд ажиллахыг уриалж байжээ.

(160-р тал). Түүнчлэн Ф.Ларсон Америкийн элчин сайдын яамны ажилчдад Монголын талаар мэдээлэл дамжуулж, “Америкийн цэргийн тагнуулын алба түүнийг мэдээллэгчээр элсүүлсэн байна.” (161-р тал). Үүний зэрэгцээ Монголын Засгийн газрын зөвлөхийн албыг давхар хашиж байв.

1916 оноос Ф.Ларсон Хүрэн дэх Америкийн худалдааны пүүсийн төлөөлөгч болсон. Оросын худалдаа эрс буурснаар Америкийн худалдааны хэмжээ нэмэгдэхэд хүргэв. Р.Болдын үзэж буйгаар “Ларсоны улс төрийн үйл ажиллагаа анхнаасаа зөрчилдөж байсан, хэд хэдэн орны тусгай албадын үйл ажиллагаанд оролцож байснаас гадна нэгэн зэрэг Хятад, Америк, Монголын талд ажиллаж байв.” (164-р тал).

Хойд Хятадын иргэний дайн АНУ-ыг Хаалган хот болон бусад консулын 4 газраа хаахад хүргэв. АНУ 1936-1939 онд Халх голд өрнөсөн үйл ажиллагааг анхааралтай ажиж байв. Уг цэргийн мөргөлдөөний шалтгаанаар япончууд маргаантай газар нутагт зах зээлээ хааж, Өвөр Монголоос мөнгөний эх үүсвэр, бараа гаргахаа зогсоосонтой холбоотой хэмээн төрийн департаментын нууц эх үүсвэр мэдээллээ.

Их гүрний гурван удирдагч нарын Ялтын бага хурал дээр “Монголын тусгаар тогтнол хуулийн дагуу ЗХУ-аар, албан ёсоор Хятадаар, харин де-факто АНУ-аар баталгаажсан” гэж Р.Болд бичжээ. (326-р тал).

Уг номондоо Р.Болд XX зууны эхэн үеийн Монголын түүх, гадаад бодлогод АНУ-ын гүйцэтгэсэн үүрэг болон Монгол-Америкийн харилцааг хэт дөвийлгөсөн нь тод харагдаж байна. Мэдээжийн хэрэг, америкийн архиваас олдсон шинэ материалууд манай улсын тусгаар тогтнох хэцүү үйл явц болон улсын хөгжлийн өөр нэг хүчин зүйлийн талаарх бидний үзлийг өргөжүүлж өгөх нь дамжиггүй. Гэхдээ, тухайн үеийн Монголын олон улсын байдалд америкийн хүчин зүйл маш бага нөлөө үзүүлж байсан гэж бид үзэж байна. АНУ-ын тэргүүлэх үүрэг гүйцэтгэхээр зүтгэж байгаа Монголд ихээхэн дэмжигддэг “гуравдагч хөршийн” бодлогыг түүхэн талаас нь үндэслэн баталгаажуулах шаардлагатай.

НОМЫН ШҮҮМЖ

Орос улс 1911-1921 онд Монголд өрнөсөн үйл явдалд чухал үүрэг гүйцэтгэсэн. Монголын зарим судлаачид Өвөр Монгол, Барга, Урианхай багтсан бүрэн тусгаар тогтносон улс байгуулахад Орос илүү их зүйлийг хийж дэмжлэг үзүүлж болох байсан гэж үздэг. Харин бидэнд Орос давхар бодлого явуулалгүй тухайн нөхцөлд тохирсон бүхий л зүйлээ хийсэн гэж бодогдож байна.

Монгол Улс 1911 оноос хятадууд дотоод хэрэгт нь оролцох эрхгүй де-факто тусгаар тогтносон улс болсон. Мэдээж, Орос тус бүс нутагт өөрийн ашиг сонирхолтой байсан ч Монгол Улс төрийн бүтэц, үндэсний санхүүгийн тогтолцоо, орчин үеийн армитай болоход чухал үүрэг гүйцэтгэсэн.

Тухайн үед Оросын гүйцэтгэсэн үүргийн талаарх зохиогчийн сөрөг үнэлгээ, америкийн хүчин зүйлийг хэт дөвийлгөсөн нь түүхэн үнэн, Монголын түүх, Монгол-Оросын харилцааны бодит нөхцөлтэй зөрчилдөж байна.

Эцэст нь дүгнэн хэлэхэд, монголын нэрт судлаач дипломат Р.Болд ХХ зууны Монголын олон улсын харилцааны түүхийн чухал бөгөөд хүнд хэцүү үе, түүн дотор тус орны гадаад харилцаанд Монгол-Америкийн харилцааны эзлэх байр суурийн талаар шинжлэх ухааны суурь судалгааны бүтээл туурвижээ. Дэлхийн монгол судлалд анх удаа уг шинжлэх ухааны асуудлыг анхдагч түүхэн эх сурвалжийн үндсэн дээр бүрэн системтэй судалсан бөгөөд зарим эх сурвалж анх удаа шинжлэх ухааны эргэлтэд орсон байна. Бидний бодлоор, зохиогчийн зарим дүгнэлт тодорхойлолт маргаантай шинж агуулж байна, ялангуяа Монголын тусгаар тогтнолыг сэргээхэд Оросын гүйцэтгэсэн үүрэг гэх мэт. Р.Болдын нэгэн сэдэвт уг зохиол Монголын түүх болон дэлхийн монгол судлалыг үлэмж хэмжээгээр баяжуулаад зогсохгүй түүхэн үнэнийг тогтооход чухал алхам болсон гэж үзэж байна.

Ю.В.Кузьмин, Ар Байгалийн их сургуулийн профессор, Монгол Улсын Их сургууль, ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн хүндэт доктор

Оохнойн Батсайхан, ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн тэргүүлэх ажилтан, түүхийн шинжлэх ухааны доктор

Орчуулсан Ж.Орхон